

## НАЙРАЛТ НАЙРАМДАХ СҮМИЙН ЖАЯГУУДЫН ШИНЖИЛГЭЭ

С.Янжинсүрэн (Доктор, PhD)  
Б.Сумъяа (Магистрант)  
МУИС, ШУС, Философи, шашин судлалын тэнхим

**Тулхүүр үс:** Сүм, хийдийн жаяг; жаяг; Найралт найрамдах сүмийн жаяг,

**Төвч утга:** Тус өгүүллэгт БНХАУ дахь Юн хэ гүн /Yong He Gong/ буюу Найралт найрамдах сүмийн үйл ажиллагаанд 2003 оноос хойш баримталж ирсэн 2 жаягийн (дүрэм) талаар өгүүллэв. Найралт найрамдах сүмийн жаяг нь БНХАУ-ын шашны талаар төрөөс баримтлах бодлоготой нь нягт холбоотой юм. Энэ жаягуудыг Найралт найрамдах сүмийн захиргаа боловсруулж дээд байгууллагаар хянуулан батлаж мөрдсөн байна.

\* \* \* \*

Шашнуудын зарим сүм хийд үйл ажиллагаагаа албан ёсны дүрэм, журмаар зохицуулж ирсэн байдаг. Буддын шашны хувьд энэ чиглэлийн бичгийн эх сурвалжууд арвин байна. Буддын сүм хийдүүдийн дүрэм, журмыг жаяг-цааз бичиг /төвд нэрээр/ гэж нэрлэдэг уламжлалтай.

БНХАУ дахь Юн хэ гүн /Yong He Gong/ буюу “Найралт найрамдах сүм” нь буддын шашны сүм бөгөөд энэ сүм эртнээс мөрдсөн жаягтгүй явж ирсэн үү, эсвэл жаягтай байгаад үрэгдсэн үү, бүр эсвээс жаяг нь хaa нэгтэй хадгалагдаж байгаа юу ямартай ч 2003 он хүртэл үйл ажиллагаандаа албан ёсоор дүрэм, журам мөрдсөн эсэх нь тодорхой биш байна. Уг нь Найралт найрамдах сүм бол Хятад, Өвөрモンгол, Төвд дэх буддын шашны түүхэнд холбогдох томоохон сүм мөнийг бодвол жаягтай баймаар. Гэхдээ жаягтгүй сүм хийд буддын сүм хийдүүдийн дотор олон байдаг юм.

Анхандаа хааны хүүгийн ордон /1694-1744/ байсан “Найралт найрамдах ордон” хожим “Найралт найрамдах сүм” /1744 оноос/ болж үүрэг, зориулалт нь өөрчлөгдсөн түүхийн эхний үедээ үйл ажиллагааг нь журамлан шийдсэн жаяг байгаагүй ч байж болно. Энэ сүмийн жаяг гэхээр бичгийн эх сурвалж өнөө хэр олдоогүй бөгөөд сүмийн түүхийг мэдэх настай хүмүүсээс асуувч тодорхой зүйл өгүүлж чадахгүй байна. Цаг явах хэрээр бичгийн эх сурвалж эс олдвоос сүмийн түүхийг өгүүлж чадах хүнгүй болох биз ээ.

Буддын шашны сүм хийдийн үйл ажиллагаа, хийдийн хүрээнд оршин суух лам нарын ёс зүйг журамлан тогтоосон бичгийн эх сурвалж болох **жаягийг** /bcha uig, цааз бичиг/ буддын шашны эрх зүйн баримт бичиг гэж үзвэл зохино.

Буддын томоохон сүм хийдүүд ихэнхдээ жаягтай байсан байдаг. Тухайлбал, Монголын соёлын амьдралд нөлөөтэй, тухайн үедээ.govийн бүсийн соёлын төв болох шахсан Зава Дамдин гавжийн байгуулсан Дэлгэрийн чойр

/одоогийн Дундговь аймгийн Дэлгэрцогт сум/, Монгол дахь жүдийн ёсны сургалт судалгааны төв болж байсан Дамцагдорж ёнзонгийн байгуулсан Ганданшадувпэлжээлин /одоогийн Дундговь аймгийн нутагт байсан, одоо байхгүй болсон/ хийдүүд болон монголын бусад олон сүм хийдүүд жаягтай байсан. Тэр хэрээрээ тухайн сүм хийдүүдийн шашны амьдралд гүйцэтгэж байсан үүрэг нь өндөр байсан байдаг.

Сүм хийдүүдийн жаягаас үзвэл, тухайн сүм хийд, түүн дэх дацан сургуулиудын түүхийг жаягийн эхэнд нь эсвэл адагт нь товч бичсэн байх нь элбэг. Ингэж үзвэл, хэрэв Найралт найрамдах сүм өмнө нь жаягтай байсан байгаад олдвол түүний түүхийн талаар нэлээд зүйл тодорхой болно гэж бичигч нар үзэж байна.

Энэ хийдийн үйл ажиллагаа Манж Чин Улсын /1644-1912/ лам нарын харьят газар, Дундад Иргэн Улсын Засгийн газар /1912-1949/, БНХАУ-ын /1949-одоо/ Шашны хэрэг эрхлэх хороо зэрэг төрийн байгууллагуудын шууд удирдлага дор явж ирсэн юм. Найралт найрамдах сүм олон төрийн олон нийгмийн харилцааг туулахдаа сүм хийдийн үндсэн үүргээ алдаагүй онцлогтой. Түүхийн ороо бусгаа үйл явдлын дунд Найралт найрамдах сүм нэг хэсэг үйл ажиллагаагаа зогсоож цөөн тооны Өвөр mongol лам нар амьдардаг газар болсон байсныг 1981 онд сэргээжээ.

Манж Чин Улсын төрийн дэмжлэг, ивээлд явж ирсэн Найралт найрамдах сүм нь Манж Чин Улс төрийн эрхээ алдахад түүнийг дагалдан Хааны сүмийн байр сууриа ч гээж, хийдийн санхүү эрс суларснаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахаа болжээ. Энэ үеэс хийдийн лам нарын too цөөрч сүм хийдийн уламжлалт сургалт алдагдсан байна.

Сүм түүхийнхээ эхэнд 500-аад ламтай байсан бол ид сэргэн мандсан үедээ "... лам нарын too 800 хүрч бүгдийг Монголын аймаг хошуудаас тогтсон хугацаагаар сонгон томилж" байсан бол Дундад Иргэн улсын үед сүм хийдийн үйл ажиллагаа нийтдээ сулран, санхүүгийн хувьд хомсдолд орсон тул "долоо найман зуун ламтай байсан Найралт найрамдах сүмийн лам нарын 4-ны 3 нь хийдээс салж, ... 200 орчим зэмдэг буурай лам нь хийдээ сахин сууж"

Үлдсэн байна. Дундад Иргэн Улсын засгийн газрын 1935 оны бүртгэлд 195 ламыг бүртгэжээ. Тус бүртгэлд лам нарын нутаг орон, албан тушаал, хүлээх үүргийг тодорхойлсон юм. Бээжин хот Япон цэргийн эзэмшилд орсны /1938-1945/ дараа Гоминданы засгийн бүртгэлийн газраас явуулсан "Найралт найрамдах сүмийн дөрвөн дацангийн цэгцлэлт" гэх бүртгэлд "Бэй Пинд 300-аад л лам байж, түүний дотор Найралт найрамдах сүмд 88 лам, бусад лам нар нь Бээжин хотын 20 гаруй хийдэд тархан суудаг" гэж тэмдэглэснээс үзвэл энэ сүм 100 хүрэхгүй ламтай болжээ.

Дундад Иргэн Улсын үед хийдийн лам нар нь хэдийгээр тооны хувьд цөөрсөн боловч 4 дацан өөр, өөрийн уламжлалт сургалт ба шашны үйл ажиллагааг зохих хэмжээгээр явуулж байв. Тухайн үед бас Иргэн улсын засгийн газар Найралт найрамдах сүмд Бэй Пингийн лам нарын сургууль байгуулах тухай санал гаргасанд тухайн үеийн Найралт найрамдах сүмийн хамба асан Гончогжунай тэргүүтэй хийдийн лам нар эсэргүүцэж энэ сургууль байгуулагдах асуудал тэгсхийгээд дарагдсан байна.

Дундад Иргэн Улсын үед Найралт найрамдах сүмийн үйл ажиллагаа суларсан боловч хуучин нэр хүнд, сүмийн хэвшиж тогтсон үйл ажиллагаа нь шашны байгууллага, сүм хийдүүдийн дунд зонхилох нөлөөгөө хадгалж үлдсэн ба түүхийнхээ бүх үед сүм хийдийнхээ үндсэн үүргээс хазайсангүй. Тухайлбал, Бай Фүрэн /白甫仁/ лам буюу Бай лам гэж алдаршсан ламын бадар барьж бүтээсэн Богд Зонхавын гуулин хөргийг 1924 онд цогчин дуганд залж равнайлах 108 ламын оролцсон 49 хоногийн хурал зохион байгуулж байв. Энэ үйл ажиллагаанд шүтлэгтэн олон идэвхтэй оролцжээ. Ийнхүү нэр хүндтэй, үйл ажиллагаа нь идэвхтэй, шашны нандин зүйлс олонтой, лам нар нь дэг журамтай тул 1925 онд IX Банчин эрдэнэ Лувсанчойжням /1883-1937/ Найралт найрамдах сүмд саатан Дүйнхор бурханы авшиг өгөх үйл ажиллагаа болсон юм.

1949 онд Хятад улс байгуулагдаж шашны талаар төрөөс явуулах бодлогоо шинээр тодорхойлов. 1951 оны 8 дугаар сараас эхлэн Бээжин хотын застийн газрын шийдвэрээр Найралт найрамдах сүмийг 2 удаа их засвар хийж сэргээжээ.

1957 оноос социализмын үзэл санааны нөлөөгөөр Найралт найрамдах сүмийн үйл ажиллагаа зогсож, ялангуяа 1966 оны соёлын хувьсгал Хятад Улс байгуулагдах үеийн шашны

талаар төрөөс баримталж байсан бодлогыг нэгмөсөн хүчингүй болгосноор энэ сүмийн лам нарыг нь хийдээс нь салган хөдөлмөрт татан оруулжээ. 1966 оны 8 дугаар сарын 22-ны өдөр Улаан хамгаалагчид Найралт найрамдах сүмийг буулгахаар дайрч орсныг тухайн үеийн Хятад улсын өрөнхий сайд асан Жоу Энлай /Zhou Enlai周恩来/ бээр зогсоожээ. Соёлын өвийг хамгаалах Жоу Энлайн бодлогоор Найралт найрамдах сүм соёлын хувьсгалын 10 жилийн үймээний талхигдалд өртөөгүй үлдсэн байна.

Цаг, төрийн эрхээр 32 жил үйл ажиллагаа нь зогссон Найралт найрамдах сүм 1981 онд нээгдэж, ингэхдээ цөөн тооны Төвд лам, бусдыг нь Өвөрモンголын аймаг, хошуудаас элсүүлэн авдаг бичигдээгүй хууль тогтжээ.

Найралт найрамдах сүм үйл ажиллагаандaa 2003 оноос жаяг боловсруулан баталж мөрдсөн байна. Сүм хийд, дацангийн жаягийг хэн нэгэн хутагт хувилгаан, эрдэмтэн лам бичсэн байдаг бол Найралт найрамдах сүмийн жаягийг сүмийн захиргааны зөвлөл боловсруулж баталжээ. Жаягийг хятад хэлээр бичсэн байна. Жаягийн агуулгаас үзэхэд Найралт найрамдах сүмийг зөвхөн сүм хийд төдийгүй соёлын өв, аялал жуулчлалын төв гэж үзэж үйл ажиллагааг нь журамлан тогтоосон нь жаягийн агуулгаас тодорхой байна.

2016 онд 2003 оны жаягийг шинэчлэн боловсруулж зарим нэг зүйл, хэд хэдэн хавсралт нэмсэн нь Найралт найрамдах сүмийн 2 дахь жаяг болно. Хоёр жаягийн ялгааг авч үзвэл дараахь байдалтай байна. Тухайлбал:




2003 оны жаяг нь 20 зүйлтэй байна. Үүнд: 1. Жуулчин, мөргөлчин хүлээн авах; 2. Лам нар зочин хүлээж авах; 3. Ажлын цаг бүртгэх; 4. Чөлөө авах; 5. Лам нарын хувцас өмсгөлд тавигдах шаардлага; 6. Захиргааны хурлын үйл ажиллагаа; 7. Дуган музейн үйл ажиллагаа; 8. Хурал хурах, 9. Шашны үйл ажиллагааг эрхлэх албаны үйл ажиллагаа; 10. Равнайлах танхимын үйл ажиллагаа; 11. Санхүүгийн үйл ажиллагаа; 12. Цалин хөлс олгох; 13. Тооцоо бүртгэл хийх; 14. Эмчилгээнд хамрагдах; 15. Шашны сургуулийн багш нарын ажил үүрэг; 16. Шашны сургуулийн сурагчдын үүрэг хариуцлага; 17. Гал тогооны ариун цэвэр; 18. Гал тогооны үйл ажиллагаа; 19. Хийдийн зочид буудлын үйл ажиллагаа; 20. Хийдийн архивын үйл ажиллагааг тус тус журамлан тогтоосон байна. Эдгээр зүйлүүд дэх агуулга давтагдах байдалтайг харгалзан Найралт найрамдах сүмийн үйл ажиллагааг дараахь 8 хэсэгт ялган тодорхойлж болно. Үүнд :

- 1. Жуулчин, мөргөлчидтэй харилцахдаа дараахь дүрмийг мөрддөг байна. Үүнд, тухайлбал:** гадаад дотоодын жуулчид, мөргөлчид байнга үйлчлүүлдэгийг харгалзаж хувцас, өмсгөлөө цэвэр цэмцгэр өмсөх; мөргөлчид, жуулчидтай зөв боловсон харьцах; үйл ажиллагаагаа БНХАУ-ын гадаад харилцааны бодлого, журамд нийцүүлэх; 08:00-20:30 цагаас бусад цагт хувийн зочин хийдийн горломд хүлээн авахгүй байх; лам нарын сууцанд орж гарах зочдыг хаалгач бүртгэх зэрэг болно.
- 2. Лам нар дараахь үүрэгтэй. Үүнд:** ажилдаа цагтаа ирэх; дуган сүмийн эд хөрөнгийг сайтар хамгаалах; ариун цэвэр сахих; хийдийн горломд лам хувцас өмсөх; мөргөлчдөд эмх журам сахиулах; Бурхан шүтээнийг зохих журмын дагуу равнайлах /амьлуулах/ зэрэг болно.
- 3. Лам нарын амралтыг дараахь байдлаар журамлажээ. Үүнд:** сард 3-аас илүүгүй өдөр амрах; ар гэр нутгаа эргэх зорилгоор жилд 15 хоногийн чөлөө авч болох; нас ахьсан лам нар жилд 25 хоногийн чөлөө авах; чөлөөний хугацаа хэтрүүлбэл цалин, зэдээс нь хасах; 2 жилд нэг удаа эцэг, эхээ эргэж очих замын зардлыг хийдээс гаргуулах эрхтэй байна.

- 4. Найралт найрамдах сүмийн лам нь хурал номын үйл ажиллагаанд дараахь дүрмийг барьж оролцно.** *Үүнд:* хурлын цагийг барих; хуралд унтахгүй, чалчихгүй байх; хувцас өмсгөлөө ёс журмын дагуу өмсөх; хурлыг унзадтай нэгэн зэрэг унших; хийдээс гарах, хийдэд буцаж ирэхдээ гэсгүйд мэдэгдэх; гэсгүй бээр мөргөлчдөд уян хатан хандаж, мөргөлчдөд уншуулах номыг нь ойлгомжтой тайлбарлаж өгөх; хурлын дэг зөрчигсдийг шийтгэх зэрэг байна.
- 5. Найралт найрамдах сүмийн санхүү нь дараахь дүрмийг үйл ажиллагаандаа баримтлана.** *Үүнд:* хийдийн орлого зарлагаа өдөрт нь данслах; зарлага бүр баримттай байх, данс баримтууд хоорондоо зөрөхгүй байх; арвилан хэмнэх; хийдийн мөнгө, санхүүг төсвийн дагуу зарцуулах; хуврагуудын зэдийг ил тод байлгах; хийдийн эд хогшлыг данслаж бүртгэх; лам нарын эмчилгээний зардлыг зохих журмын дагуу олгох зэрэг болно.
- 6. Найралт найрамдах сүм лам нарынхаа сургалтанд дараахь журмыг баримтална.** *Үүнд:* хийд нь дэргэдээ шашны сургуультай байж, шашны сургууль нь “Бодь мөрийн зэрэг”, “Оюун судлахай” зэрэг бурханы шашны үндсэн зохиолуудыг гарын авлагы болгож сургалт явуулах; сахил санваараа нүдний цөцгий мэт сахих; улсын хууль цааз, дүрэм журмыг биелүүлэх; ёс суртхууныг дээдлэх; багш ламаа ёсчлон шүтэх; хичээлээс өмнө “Итгэл” гурвантаа уншин сэтгэлээ засах; сурсан номоо бататган давтах зэрэг болно.
- Сүмийн дэргэдэх шашны сургуулийн багш нь багшийн бэлгэ төгс байх; багш хоорондын эвийг эрхэмлэх; багш, шавийн харилцаанд ёс журмыг сахих зэрэг үүрэгтэй.
- 7. Найралт найрамдах сүмийн гал тогооны үйл ажиллагааг сүмийн жаягаар зохицуулсан байна.** *Үүнд:* Тогооч нь тогоочийн мэргэжлийн үнэмлэхтэй байх; ажилдаа хүндэтгэлтэй хандах; гал тогооны багаж хэрэгсэл болон малгай хувцсаа байнга ариутгах болон цэвэрлэх; хоол хүнсэнд шинэ хүнс ногоо сонгож хэрэглэх; ариун цэвэр сахих; хоолыг цагт нь хийх; хоолны төлбөрийг тогтоосон дагуу хураах зэрэг үүрэгтэй.
- 8. Жаягт сүмийн албан бичигт баримтлах журмыг тогтоосон байна.** *Үүнд,* бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнтэй байх /хар хүн байна/; өмнөх оны албан бичгийг дараа оны 3 дугаар сард багтаан цуглуулах; цуглуулсан албан бичгээ 6 дугаар сард багтаан дансалж архивлах; албан бичигт хар эсвэл хөх бэх хэрэглэх; албан бичгийг хэн, хэзээ үйлдсэн, хэн хянасан нь тодорхой байх; хийдийн түүх, үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн баримтуудыг нягт нямбай цуглуулж данслах; шаардлагатай үед хийдийн үйл ажиллагааны талаар тэмдэглэл хөтлөх; нууцын зэрэглэлтэй албан бичигтэй зохих албан тушаалтнаас зөвшөөрөл авч танилцах; энгийн албан бичгийг 15 жил хадгалах; устгах албан бичгийг ажлын хэсэг гарч тогтоох журамтай байна.

Эндээс үзвэл Найралт найрамдах сүмийн энэ жаяг нь орчин цагийн нийгмийн харилцааны хэлбэрүүдийг шашны институц, лам нарын үйл ажиллагаа аль алийг орхилгүй зохицуулсан онцлогтой байна. Энэ сүмийн лам нарын гол үүрэг нь Найралт найрамдах сүмийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, дэлхийн соёлын өвийн дархан байдлыг хангах явдал болно. Түүний сацуу шүтлэгтэн олны сүсэг бишрэлийн хэрэгцээг хангах, бурханы шашны ном, сургаалаар соён гэгээрүүлэх үүрэгтэй байна. Монголын сүм хийдийн жаягаас ялгаатай нь тус сүмийн жаягийг сүм хийд өөрөө боловсруулаагүйгээс гадна улсын хуулийг сахиж мөрдөхийг жаягт тусгасан байна.

2003 онд баталсан тус жаягийг Найралт найрамдах сүм үйл ажиллагаандаа 13 жил мөрдөөд 2016 оны 1 дүгээр сараас шинэ жаяг батлан мөрдөж эхэлжээ.



2016 онд хийдийн захираганаас баталсан шинэ жаяг нь хуучин жаягийг эх сурвалжаа болгожээ. Ингэхдээ зарим зүйл заалтыг нэмсэн байна. Үүнд: Бурхан шүтээнийг амьлуулж равнайлахдаа сүсэгтнүүдээс үнэ хөлс авахгүй байх; ажлаасаа 4-өөс дээш удаа хоцорвол, эсвэл цагаас эрт ажлаа дуусгавал хийдээс хөөх; төрөл төрөгсөд нь нас барвал 7 хоногийн чөлөө авч болохоор нэмсэн баар гэр болон нутгаа эргэх чөлөөний хугацааг богиносгож 15 хоног байсныг 12 хоног болгон цөөлжээ.

Шинэ жаягт лам нарыг шагнаж урамшуулах болон гэм алдал гаргасан тохиолдолд шийтгэх заалтуудыг шинээр нэмсэн юм. Тухайлбал, шагшабадыг /lam нарын ёс зүй/ сайн сахьсан хийгээд эрдэм ном сайн сурсан, үүрэгт ажлаа зохих журмын дагуу сайн хийсэн, хийдийн нэр хүндийг өндөрт өргөсөн, хийдэд биет болон

биет бус хөрөнгө оруулсан, гэнэтийн ослоос болон гамшигаас хийдээ хамгаалсан, мөргөлчид, жуулчдыг гамшигаас урьдчилан сэргийлсэн, шинэ бүтээл оновчтой санал гаргасан, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж хийдээ хөрөнгө, ашиг оруулсан, өөрийн сургуулиас өөр сургуульд амжилттай суралцаж шилдгээр шалгарсан тохиолдлуудад тус тус батламж олгох эсвэл мөнгөн урамжшуулал өгч, нутаг орон, гэр бүл, төрөл төрөгсдөд нь баяр хүргэж алдаршуулах журам тогтоожээ.

Нэг угээр хэлбэл энэ жаяг Найралт найрамдах сүмийн лам нарын үйл ажиллагааг идэвхжүүлэх, урам зоригийг нь сэргээх хэрэгсэл болсон байна. Хуучин жаягт лам нарыг сайн үйл бүтээснийх нь төлөө болон ололт амжилт гаргасныг нь урамшуулах тухай нэг ч заалт байхгүй юм.

Улсын хуулийг болон гадаад харилцааны журам зөрчсөн, улсынхаа нэр хүндийг гутаасан, үндэстнүүдийн эв нэгдлийг сарниулсан, сахил санваараа алдсан, хийдийн жаягийг зөрчсөн, жуулчид болон мөргөлчидтэй бүдүүлэг харьцсан, ёс суртахуунгүй зан авир гаргасан, хэрүүл хийсэн, хийдийн гадна биеэ буруу авч явсан, хийдийн эд хогшлыг эвдсэн, алдсан ламд хөнгөнөөс нь хүндрүүлэх дарааллаар шийтгэлийн төрлүүдийг тогтоожээ. Үүнд, шүүмжилж баалах, мөнгөөр торгох, сануулга өгөх, лам нарын өмнө буруут нь хулээлгэж гэмшүүлэх, болзол өгч тэнсэх, ятгаж нутагт нь буцаах арга хэмжээ авна. Архи уух тэргүүтнээр сахил санваараа ноцтой зөрчсөн ламыг хийдээс хөөнө. Эдгээр нь Монголын сүм хийдүүдийн жаягт байдаг жаяг зөрчсөн, гэм унал гаргасан ламд ногдуулдаг шийтгэлтэй ерөнхийдөө дүйж байна.

Болзол өгч тэнсэх шийтгэл авсан, ятгалгаар нутаг буцсан, хийдээс хөөгдсөн лам нарыг нутаг орон, эцэг эхэд нь энэ тухай мэдэгдэхээр шинэ жаягт тусгажээ. Энэ зүйл заалт Монгол сүм хийдийн жаягт байдаггүй, гагцхүү хийдээс хөөх тухай заасан байдаг юм.

Шинэ жаягт хийдийн албан ёсны зочдыг хэрхэн дайлж зочлох, ямар хэмжээний гарын бэлэг өгөхийг журамлажээ. Ингэхдээ ямагт арвилан хэмнэх зарчмыг удирдлага болохоор тогтоосон байна. Тухайлбал хийдтэй албан ёсны харилцаатай байгууллага, хувь хүмүүсийг албан журмаар дайлахдаа 10 зочинтой дайллагад хийдээс 3 хүн оролцох, 10-аас дээш хүнийг дайлах тохиолдолд тэдний гуравны нэгтэй тэнцэх тооны хүн хийдээс дайллагад оролцох, өндөр зэрэглэлийн уушийн газраар үйлчлүүлэхгүй байх, тогтоосон төсвийг хэтрүүлж зочлохгүй байх, албан бус аялал, дайллага зохион байгуулахгүй байхаар, албан ёсны хүлээн авалтын санхүүгийн баримтыг үнэн зөв бурдүүлж санхүүд тушаахаар тус тус журамлажээ.

Ийнхүү Найралт найрамдах сүмийн жаягт зочдыг дайлах, тэдэнд гарын бэлэг өгөх тухай тусгаж журамлан тогтоосон байгаа нь хятадын соёлтой салшгүй холбоотой. Хятад соёлд зочиноо дайлах, бэлэг сэлт өгөх нь ёслол, хүндэтгэлийн хамгийн чухал хэсэг нь болдог.

Сүмийн шинэ жаягт гал түймэр зэрэг гэнэтийн осол, хулгай дээрмээс сэргийлэх, түүхийн дурсгалт эд өлгийн зүйлийг эвдэхээс тус тус урьдчилан сэргийлэх, жуулчид хийгээд мөргөлчдийн тайван байдлыг хангах буюу аюулгүй ажиллагааны заалтуудыг нэмсэн байна.

Мөн албаны машиныг хувийн зорилгоор хэрэглэхийг болон лам нарыг машин эзэмшихийг хориглосон ба хэрэв машин жолоодож яваад осол гаргавал хариуцлагыг лам өөрөө хүлээхээр зохицуулсан байна.

Мөн түүнчлэн, шинэ жаягт 4 шинэ хавсралт нэмжээ. Үүнд:

1. “Шашны хэрэг эрхлэх журам”,
  2. “Төвд уламжлалын Буддын шашны сүм хийдийг удирдах арга зүй”,
  3. “Төвд уламжлалын Буддын шашны албан тушаалтнуудын эрэмбийг тогтоох арга зүй”,
  4. “Төвд уламжлалын Буддын шашны хутагт хувилгаадыг удирдлагаар хангах арга зүй”
- гэсэн 4 баримт бичгийг жаягт хавсаргасан байна.

Эдгээр баримт бичгүүд нь зөвхөн Найралт найрамдах сүмийн үйл ажиллагаанд хамаатай биш БНХАУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт буддын шашны сүм хийдийн үйл ажиллагаанд хамаатай юм. Тэдгээр баримт бичгүүдээр дамжин БНХАУ-ын териийн зөвлөл болон засаг захиргаанаас сүм хийд, шашны үйл ажиллагаанд баримталж байгаа албан ёсны бодлого хэрэгжиж байгаа болно.

Хоёр жаягийг харьцуулан үзвэл нь хуучин жаягт гадаад, дотоодын жуулчдад үйлчлэх асуудлыг чухалчилсан бол шинэ жаягт шашны үйл ажиллагаанд дэг ёс, сахилга бат сахихыг гол агуулгаа болгосон нь лам нарын амьдрал, үйл ажиллагаанд илүү ойр болжээ. Мөн түүнчлэн БНХАУ-д шашнуудын үйл ажиллагаа идэвхижиж, культууд олноороо бий болж төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж байгаатай холбож ойлговол зохино.

Найралт найрамдах сүм нь эдгээр жаягийг удирдлага болгон винайн ёсонд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг. Залуу лам нарыг сурган хүмүүжүүлсэн, боловсруулсан, мөргөлчид болон жуулчдын шүтэх хийгээд танин мэдэх эрэлт хэрэгцээг нь хангасан, тэднийг бурханы шашны агуулгаар соён гэгээрүүлсэн тул БНХАУ дахь олон шашны сүм хийдийн дотроос дэг ёсоороо шалгарч “Эе зохицолт шилдэг сүм хийд” хэмээх шагналаар төрөөсөө шагнуулжээ. Эл бүхий байдал нь бусад сүм хийдүүдэд Найралт найрамдах сүм үйл ажиллагаагаараа үлгэр дуурайл болж байна гэж дүгнэх үндэстэй юм.

Одоо Найралт найрамдах сүмд Гүмбүм, Лавранд сууж байсан өндөр настай болон Лаврангийн шашны сургуульд суралцаж төгссөн залуу лам нийлээд бүгд 93 лам хурж байна.

Өнөөдөр /2018 он/ энэ хийдэд шавилан сууж байгаа лам нарыг нутаг ус, насаар нь ялгавал:

Нутаг Нас	ӨМӨЗО (74 Монгол)	Хөхнуур муж (5 Төвд, 1 Монгол нийт 6)	Лио Нин муж (13 Монгол)
18 – 30	40	0	6
30 – 40	19	0	1
40 – 50	6	2	1
50 – 60	3	2	4
60 – 90	4	2	1
90-ээс дээш	2	0	0
Нийт	93		

Найралт найрамдах сүмийн лам нарын тоог Бээжин хот дахь Шашны хэрэг эрхлэх хорооноос 120 гэж тогтоосон байдаг. Одоо сүмд 27 сул орон тоо байна.

Лам нарын зарим нь хувийн шалтгаанаар хийдийн харьяанаас гардаг. Ийм тохиолдолд нөхөн элсэлт явуулна. Элсэлтийг 2-3 жилд 1 удаа зохион байгуулна. Найралт найрамдах сум элсэлтийн үйл ажиллагааг Шашны хэрэг эрхлэх товчооноос өргөдлөөр дамжуулан зөвшөөрөл авч зохион байгуулдаг журамтай. Хороо зөвшөөрвэл ΘМӨЗО-ны Шашны хэрэг эрхлэх хороонд аль аймгаас хэдэн лам элсүүлэх тухай саналаа бичгээр өгнэ. ΘМӨЗО-ны Шашны хэрэг эрхлэх хороо нь аймаг, аймгаас хошууны Шашны хэрэг эрхлэх газарт мэдэгдэн тухайн газар оронд зар түгээнэ. Элсэлтийг тогтсон өдөр тусгай ажлын хэсгийн бүрэлдэхүүн тухайн нутгийн Шашны хэрэг эрхлэх газрын хүмүүстэй хамтран зохион байгуулна.

Элсэлтэд дараах жurmыг баримталдаг. Үүнд: 16–20 настай царай зүс төв, 9 жилийн албан журмын сурган хүмүүжил төгссөн /дор хаяж бүрэн бус дунд боловсролтой/, хууль бус үйл ажиллагаанд оролцож байгаагүй, ял шийтгэлгүй, эцэг эх нь хийдийн сурагалтанд суухыг нь зөвшөөрсөн, өөрөө лам байх дур сонирхолтой өвөрモンгол хүүхдийг монгол, хятад хэлний төвшин тогтоох шалгалт авч элсүүлнэ.

Найралт найрамдах сүмд шинээр элссэн ламыг 1 жилийн хяналтын хугацаанд идэвхи чармайлттай сурхыг нь дэмжиж хийдийн хурал номд хурах үйл ажиллагаа, болон дуган сум харах зэрэг бусад олон ажлаас чөлөөлдөг. Хяналтын хугацаа дуусмагц шалгалт аваад тэнцвэл сахил өгч хийдийн албан ёсны лам болгож үлдээдэг юм. Нэг үгээр хэлбэл хяналтын нэг жил нь түүний сүмд үлдэж чадах эсэх гол шалгуур нь болдог байна.

Сүмийн лам нарт сахил хүртээх үйл явц нь хатуу дэгтэй. Сүмийн үйл ажиллагаа сэргэсэн эхний үед Бээжин хотын Шар сум буюу Төвд уламжлалын Буддын шашны дээд сургуулийн захирал агсан Лхарамба Чэшой /Che shos, Гүмбүм хийдийн хувилгаан/ гэгээнтэн лам нарт гэцэл, гэлэн сахил хүртээдэг байжээ. 1990-ээд оноос хойш өнөөдрийг хүртэл Найралт найрамдах сүмийн хамба лам асан, одоо бол дархан хамбаар өргөмжлөгдсөн бөгөөд хийддээ судаг Жамъянтувдэн ламтан бээр сахил хүртээж байна. Тэрээр 94 настай.

Өнөөдөр сүмийн албан ёсны хамбаар Лувсансамдан ламтан томилогдон ажиллаж байгаа ба сүмийн 93 хуврагаас 30 гаруй нь гэлэн сахилтай, үлдэх нь гэцэл сахилтай.

Хийдийн лам нарын зэрэг дэв, албан тушаал нь: 1 тэргүүн хамба, 1 дэд хамба, 1 их дэмч, 3 туслах дэмч, 2 гэсгүй, 2 унзад, 5-6 багш, 2 нярав, 8 гадаав /skad 'dra ra буюу Монголд голч лам гэдэг/, 2 балинч, 2 чавар /chab rił, гэсгүйн туслагч/ зэрэг болно. Үүнд гэсгүй нь 2 жилийн хугацаатай, бусад тушаалын лам нар нь тогтмол бус хугацаагаар тушаал эрхэлнэ.

Найралт найрамдах сүмийн лам нар хийдээр зочлох мөргөлчид, жуулчдын шүтлэгийн хэрэгцээг хангаж тасралтгүй ном хурдаг. Ном хурах үйл ажиллагааг хэн нэгэн бээр цаасанд булгаж баталгаажулаагүй ч огт зөрчигдөхгүй явагддаг үйл ажиллагаа юм.<sup>1</sup> Хурлуудын хурах сар өдрийг зөвхөн 9 дүгээр сарын Ямандаг бурханы дүвчодын хурлаас бусдыг хятад билгийн тооллын дагуу тогтоодог.

БНХАУ байгуулагдсан 1949 оны 10 дугаар сарын 1-ний дурсгалт түүхэн өдрийг Найралт найрамдах сүм улс орны энх тайван, амар амгаланг бэлгэдэн даатгаж хурал хурдаг уламжлал тогтжээ. Энэ заншил 1990-ээд оноос эхэлсэн бөгөөд жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдөр энх тайвны төлөө хурал хурдаг юм.

<sup>1</sup> Одоо хийдийн үйл ажиллагаан нь: Өдөр бүр 5:30 – 7:30 хүртэл манж хурна; Сар бүрийн шинийн 1-нд Ямандаг бурхнаар ядамлан Гомбо /mgon po/, Гонгорын /mgon dkar/ хангал хурна; Сар бүрийн шинийн 2-нд хийдийн сахьс болох Гуан гүн буюу Бринрин жалбууний өчил залбирлын зан үйл хурна; Сар бүрийн шинийн 8-нд Манал хурна; Сар бүрийн 10-нд Цэвэгмэдийн чога хурна; Сар бүрийн 15-нд Ямандаг бурхнаар ядамлан Намсрай, Чойжилын хангал, Намдагсан буюу Тийн ариун сан унших, Сојсон буюу Сэлэн арилгах зан үйл хурна; Сар бүрийн 29-нд Гүнрэгийн /kìn rig/ чога хурна ; Сар бүрийн 30-нд Жижид ганц баатраар ядамлан Лхам охин тэнгэр, Чойжилын хангал ба Сојсон хурна; Цагаан сарын шинийн 1-ний

Найралт найрамдах сүмийн дэргэдэх “Шашны сургууль” нь төвд хэл, төвд хэлний зүй, төвд уран бичлэг, магтаал, ерөөл, таван догшид цээжлэх, хурлын зан үйл, “Бодь мөрийн зэрэг”, тогтсон таалал, уншлагын ая дан, бурханы шашны түүх, хятад болон англи хэлний сургалтын хөтөлбөрүүдийг тус тус хэрэгжүүлдэг.

Шашны сургууль нь анхан, дунд, дээд шатны болон холимог 4 ангитай. Анхан шатны ангид төвд хэлний цагаан толгойгоос эхлэн сурч хурлын уншлага цээжлэн төвд уран бичлэгийн болон хятад хэлний хичээл үзнэ. Дунд шатанд орчуулга, төвөд хэлний зүй, хятад хэл, хурлын уншлага, Жамбалшалтүн /jam dpal zhal lung/ буюу Манзуширийн аман зарлиг<sup>2</sup>, Ламриммартид /lam rim dmar khid/ буюу Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр<sup>3</sup>, Саламнамшаг /sa lam mam bztag/ буюу Газар мөрийн ялгавар, Тогтсон таалал эрдэнийн эрх /grub mtha` rin chen phreng ba/ зэрэг буддын гүн ухааны судар номуудыг судална.

Дээд шатанд хурлын зан үйлд сурахын сацуу Их бодь мөрийн зэрэг<sup>4</sup>-ийг судалж, хятад хэл,санскрит хэл үзнэ.

Холимог ангид 60 наснаас дооших бүх лам нар хамрагдаж, буддын шашны бусад хийд, их дээд сургуулиас багш урьж Энэтхэгийн бурханы шашны түүх, Хятадын бурханы шашны түүх, Төвд, Монголын бурханы шашны түүх болон Англи хэлний сургалтанд хамрагддаг юм.

Энэ сүмийн лам нарын нэг өдрийн амьдрал нь өглөө 05:30-аас цогчин хуралдаа хурж, хурлын дараа дуган сүмээ цэвэрлэх ажлыг хийнэ. 9:00-17:00 цагийн хооронд буюу хийдийн

---

*Үүрээр Ямандааг бурхнаар ядамлан Лхам сухиусны Шэгдор /gshegs gtor/ буюу Лхам залрах балингийн зан үйл хурна; Цагаан сарын 24-нөөс /30-ны өдөр үгүй бол 23-аас эхэлнэ/ 8 өдрийн их ерөөл хурж, 7 дахь өдөр нь цам цамнан сор /zor/ гаргана; Цагаан сарын их ерөөлийн суулчийн өдөр буюу 2 дугаар сарын шинийн 1-нд майдар эргэнэ. Майдар эргэхдээ хийдийн 4 зүгт 4 удаа угаал мандал өргөн, өмнө зүгт цам цамнана; 3 дугаар сарын 15-нд Жамбалсанжисд /jam dpal mtshan brjpd/ буюу Манзушир бурханы магтаал унших хурал хурна; 4 дүгээр сарын шинийн 1-нээс эхлэн цогчин хуралд өдөр бүр Ганжуур Данжуурун 3 боть уншина; 4 дүгээр сарын шинийн 7,8-нд хэсэг лам Ярнай буюу зуны оршил хурна; 4 дүгээр сарын 13-15 хуртэл Зонхав боддын Дончид /stong mtchod/ буюу Мянган тахилын хурна; 5 дугаар сарын 13, 6 дугаар сарын 24-нд Гуан гүн буюу Бринрин жалбугийн өчил залбирлын зан үйл хурна, үүнээс 5 дугаар сарын 13-ны өдрийг Гуан гүнг сахиус хутгаа билүүдсэн өдөр гээдэг; 9 дүгээр сарын 22-нд Бурхан багши тэнгэрийн орноос хүний ертөнцөд заларсан өдрийг тэмдэглэн Намжилма /gnat rgyal ta/ бурханы Дончид буюу Мянган тахилын хурал хурна.*

*Аргын тоолтын 9 дүгээр сарын 15-аас Ямандааг бурханы дүүцэн жинхор /tdu l tson dkyil 'khor/ буюу шороон бүдгийн хот мандал бүтээж, 23–26 хуртэл Ямандааг бурханы дүүчэд /grub mtchod/ буюу бүтээл тахилын зан үйл хурж, 27 – 29 хуртэлх 3 өдрүүдэд 2 жинсрэг /sbuiin sreg/ буюу гол мандал бүхий Гэлэг жамцын чарвэв /dge legs rgya mtsho'i char 'bebs/ гэх дэлгэрэнгүй равнайн зан үйл хурна. Энэ хурлын үеэр БНХАУ байгуулагдсан 1949 оны 10 дугаар сарын 1-ний дурсгалт түүхэн өдрийг тдурсажэ үлс орон энх тайван, амар амгалан байхыг даатгаж хурал хурна. Энэ зан үйл 1900-ээд оноос эхлэн жил бүрийн 10 сарын 1-ний өдөр үйлдэг болсон юм; 10 дугаар сарын 25-ны бодг Зонховын няраван дүр үзүүлснийг тэмдэглэн хурал хурж Ламын тахилын ном уншина; 11 дүгээр сарын шинийн 1-ний IV Банчин бодгын таалал төгссөн өдөрт зориулан хурал хурж Ламын тахилын ном уншина, /gzhadээ шинийн 1-нд тогтолцогт хуралтай болохоор энэ хурлаа дараа өдөр нь буюу 11 дүгээр сарын 2-д хурна/; 12 дугаар сарын шинийн 8-ны өглөөний цогчин хуралд 2 лам цоглонд босож ном хэлэлцэнэ, хэлэлцэх номын гол агуулга нь билэг баримадын ухаан дахь Сэмжид /sems bskyed/ буюу Сэтгэл үүсгэх ба Чойнхор /choi 'khor/ буюу Номын хүрдийг эргүүлэх гэх бүлгүүдээс сэдэвлэнэ. Энэ цоглонг Повор /glo bur/ цоглон буюу Түр зуурын мэтгэлцээн гэж нэрлэдэг. Дацаангас зохион байгуулдаг цоглонтой харыуулбал нэлээд хураангуй байдаг. Энэ цоглонгийн үүсэл нь бол Найралт найрамдах ордон сүм хийд болсноос хойши 2 жилийн дараа буюу 1746 оны цагаан сард Их ерөөлийн хурал хурах ёсыг шинээр эхлүүлж Тэнгэрийнтэгэсэн хаан энэ хуралд оролцжээ. Хааны тааллыг баясгах зорилгоор Жанжа Ролбидорж ба Алтан ширээнт Лувсандамбийнам хоёр цоглонд босож номын мэтгэлцээн өрнүүлжээ. Үүнээс уламжлан энэ өдөр цоглон босох үйл ажиллагаа нь виөөдөр хуртэл үргэлжилсээр бий; Битүүний өдөр Ямандааг ганц баатар бурхнаар ядамлан Чойжилын хангальхурах зэрэг хурал номтой.*

<sup>2</sup> V Далай лам Агаанлуvsанжамцын зохиол, зохиолын бүрэн нэр нь “Бодь мөрийн зэргийн хөтөлбөр Манзуширийн аман зарлиг хэмээх оршив”.

<sup>3</sup> IV Банчин Лувсанчойжасалцаны зохиол, зохиолын бүрэн нэр нь “Бодь мөрийн зэргийн улаан хөтөлбөр хамгийг айлдагч дор одохын амгалан мөр хэмээх оршив”.

<sup>4</sup> Богд Зонховын зохиол, зохиолын бүрэн нэр нь Сацал үгүй их Зонхов бээр зохиосон их бодь мөрийн зэрэг оршив.

хаалга нээлттэй үед дуган сүмээ жижүүрлэн харгалзаж, оройн цав зооглосны дараа 18:30-20:00 хүртэл хичээллэнэ. Энэ сургалт хагас сайнаас бусад бүх өдрийн орой бүр явагддаг. Хийдийн үйл ажиллагааг оройн 21:00 цагт зогсоож хаалга барин гарч, орохыг хориглоно. Ийнхүү жилийн 4 улиралд тасралтгүй үргэлжилдэг амьдралын энэ хэв маяг нь хийдийн лам нарыг хөдөлмөрч зан суртахуунд сургадаг байна.

Найралт найрамдах сүмийн ламын хувцас 3 терөл байна. Үүнд: лам хувцас, лам дээл, охор цамц орно. Лам хувцас нь бусад буддын шашны төвд уламжлалтай лам нарын хувцас лутгаа адил орхимж, шамтав /sham thabs/ буюу хормогч, донгаг /stod 'gag/ буюу цээживчээс бүрдсэн байна. Зуны эхэн сарын 15-аас намрын дунд сарын 30 хүртэлх хугацаанд хурах бүх хурал номын үед энэ лам хувцсыг өмсөнө.

Лам дээл нь хүрэн бор өнгөтэй монгол дээл /гэхдээ оноотой/ болно. Лам хувраг болоод 1-10 жил болж байгаа лам улаан, 10-аас дээш жил болсон лам шар өнгийн бүс бүсэлнэ. Өвлийн эхэн сарын шинийн 1-ээс өвлийн сүүл сарын 30 хүртэлх хугацаанд хурал ном хурах үед дээлэн дээрээ орхимж нөмөрнө. Бас зуны дунд сарын шинийн 1-ээс намрын дунд сарын 30 хүртэлх хугацаанд дуган сүм харах ба хичээлд суухдаа дээлээ өмсөнө.



Охор цамцыг улаан өнгөтэй нимгэн торго, бөсөөр оёх ба түүний доор нь бор хүрэн өнгөтэй өмд тохируулан өмсөнө. Энэ цамц нь Бээжингийн зуны улирлын халуунд зохицсон байдаг. Зуны эхэн сарын 15-аас намрын дунд сарын 30 хүртэл хурал номд хурахаас бусад үйл ажиллагаанд буюу дуган сүм харах хийгээд сургалтанд хамрагдах үедээ өмсөнө.

Үүнээс гадна сэргүүний улиралд хурал ном хурах үед нөмөрдөг хуниас гарган оёсон дагам /zla gam/ буюу “жанч” бий. Энэ хийдийн лам нарын жанч нь шар өнгөтэй байснаа 1990-ээд онд зөвхөн хамба лам шар өнгөтэй жанч нөмөрч, бусад лам нар улаан өнгөтэйг нөмөрдөг болгожээ. Жанчийг өвлийн эхэн сарын шинийн 1-ээс хаврын эхэн сарын шинийн 1 хүртэл нөмөрнө.

Найралт найрамдах сүм нь хурал ном, шашны үйл ажиллагаанаас гадна гадна бас нийгмийн үйл ажиллагаа явуулдаг юм. Жишээлбэл: жил бүр Хятад орны бусад сүм хийд болон Өвөрモンголын сүм хийдүүдээр дуган шүтээн равнайлах, хурал ном зохион байгуулах, сүм хийд байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үнэ төлбөргүй эмчилгээ хийх, мөн Өвөрмонгол, Лио нин /辽宁/ болон Юун нань /云南/ мужийн хөдөө орон нутагт сургууль байгуулжээ.

Ийнхүү Найралт Найрамдах сүм түүхэн үйл ажиллагааг ч хадгалж явуулахын сацуу

түүнийг баяжуулж өргөтгөж байна. Бас үйл ажиллагаагаа дүрэм журмын дагуу зохицуулах болж улам эмх цэгцтэй сүм хийд болж орчин үежиж байна. Найралт найрамдах сүм бүхэлдээ түүх, соёлын хосгүй үнэт бүтээл бөгөөд цаашид судалж илрүүлүүштэй эд өлгийн зүйл болон нийгэм түүхийн үзэгдэл, үйл ажиллагаа ч энд уламжлагдан хадгалагдаж байна.

## ABSTRACT

Religious Institutions such as monasteries and temples have a bCa yig /in tibetan/ or a Monastic Order.

In this paper we consider about the Order for Yong He gong buddhist monastery in China. Yong He Gong is a famous monastery in Beijing. It has a long and rich history. But we have not found a Order belongs to its old history, but modern.

We discovered Yong He Gong's two versions of it's Order. First is written in 2003. Now following Order is written in 2016. Both are very young. But they have several difference. They show changing of chinese religious life.

First Order dedicated to how to manage of Yong He gong's activity as tourist centre.

The new version is dedicated to how to manage it's lama's daily life, daily activity and their morality. This Order have 4 attachments, which are belongs to religious activity in China. These attachments not only for Yong He Gong, but all religious institutions in China territory.

## НОМ ЗҮЙ

1. Зава Дамдин Лувсандаян. Их монгол оронд бурханы шашин дэлгэрсэн түүх “Алтан дэвтэр”, орч: С.Гантэмэр, УБ., 2014.
2. Лувсансамдувням. Гэтэлгэгчдээдламадилтгалүгүй ачитбогд Сумадишилашибрагийн гэгээний ерөнхий зохиол, намтрыг товчийн төдий өгүүлсэн Сүсгийн лянхуаг мишээлгэгч нарны гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив, модон бар.
3. Сүмбэ хамба Ишбалжир. Хутагтын орон, их хятад, төвөд хийгээд монгол оронд дээдсийн ном гарсан ёс Галбарвас мод хэмээгдэх оршив, орч: Бэсүд Ням-Очир, УБ., 2017.
4. А.Очир нар Кирил бичигт буулгаж, тайлбар хийсэн. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастирын хураангуй, дэд боть, УБ., 1997.
5. Д.Дэмбэрэлдорж, Э.Равдан. Бурханы шашны нэрийн тайлбар толь, Нэмэн засварласан хоёр дахь хэвлэл, УБ., 2015.
6. Намжилма эмхэлсэн. Хорин наймт тайлбар толь, ӨМӨЗО., 2014.
7. 'Jigs med rig pa'i rdo rje. Chen po hor gyi yul du dam pa'i chos ji ltar byung ba'i tshul bshad pa rgyal ba'i bstan pa rin po che gsal bar byed pa'i sgron me zhes bya ba bzhugs so. /Жигмэдригвидорж, Их Монголын орон дор богдсын ном ямар мэт дэлгэрсэн ёсыг өгүүлсэн ялгуусаны шашин эрдэнийг тодруулан үйлдэгч зул хэмээх оршивой, Хөхнуурын үндэстний хэвлэлийн хороо., 1993./
8. dKon mchog 'jigs med dbang po. rje bla ma srid zhi'i gtsug rgyan Pan chen thams cad mkhen pa blo bzang dpal ldan ye she dpal bzang po'i zhal snga nas kyi rnam par thar pa nhi ma'i 'od zer zhes bya ba bzhugs so. /Гончогжигмэдванбу. Богд лам сансар амарлингуйн оройн чимэг Банчин хамгийг айлдагч Лувсанбалдан-Ишбалсанбуу гэгээний намтар, Нарны гэрэл хэмээгдэх оршивой. Бээжин., Дундад улсын төвд судлалын хэвлэлийн хороо, 2002.6./
9. Thu'u bkvan Chos kyi nyi ma. khab bdag rdo rje sems dpa'i ngo bo dpal ldan bla ma dam pa ye she bstan pa'i sgron me dpal bzang po'i rnam bar thar pa mdo tsam brjod pa dGe ldan bstan pa'i mdzes rgyan zhes bya ba bzhugs. /Түгээмэлийн эзэн Очирсадын мөн чанар цог

төгөлдөр дээд лам Ишданбидонмэбалсанбуын намтар ховчийн төдий өгүүлсэн Буян төгөлдөр шашны чимэг хэмээгдэх оршив, Ган сүгийн үндэстний хэвлэлийн хороо., 1989.11. /

10. F.D.Lessing. Yung Ho Kung, Stockholm., 1942.
11. Buddhist Statues in Yong he Gong, 雍和宮佛像宝典, 北京., 2002. /Найралт найрамдах сүм дэх бурханы баримлууд, Бээжин., 2002./
12. Beautiful Tangka Paintings in Yong he Gong, 雍和宮唐卡瑰宝 (上, 下册),北京., 2002. /Найралт найрамдах сүм дэх шүтээн зургууд (дээд, доод дэвтэр), Бээжин., 2002.
13. 金梁. 雍和宮志略, 北京., 1994. /Жин лиан. Найралт найрамдах сүмийн түүхэн тойм, Бээжин., 1994./
14. 李立祥, 李颖. 雍和宮, 北京., 2015. /Ли ли шиан, Ли ен. Найралт найрамдах сүм, Бээжин., 2015./
15. 李德成. 略谈雍和宮的历史地位, 雍和宮改庙250周年文集, 中国西藏(增刊), 北京., / Ли дэ чэн. Найралт найрамдах сүмийн түүхийг товч өгүүлэх нь, Найралт найрамдах сүмийг хийд болгосны 250 жилийн ойд зориулсан түүвэр зохиол, Дундад улсын Төвөд (нэмэлт) сэтгүүл, Бээжин., 1994.10./
16. 李德成. 藏传佛教与北京, 北京., 2009.4. Ли дэ чэн. /Төвөд уламжлалын бурханы шашина ба Бээжин, Бээжин., 2009.4./
17. 李德成. 雍和宮与北京精神研究, 北京., 2014. /Ли дэ чэн. Найралт найрамдах сүм ба Бээжингийн бодлого, Бээжин., 2014./
18. 牛颂. 雍和宮, 当代中国出版社.北京., 2002. /Ниу Сөн, Найралт найрамдах сүм, Орчин үеийн дундад улс хэвлэлийн хороо, Бээжин., 2002./
19. 清代雍和宮档案史料 (共 24 册), 北京., 2004. /Чин гүрний үеийн Найралт найрамдах сүмийн эвхмэл данс, түүхэн материал (24 дэвтэр), Бээжин., 2004.
20. 雍和宮导观所刊物, 第2期, 北京., /Найралт найрамдах сүмээр аялуулах газрын сэтгүүл, 2 дугаар дэвтэр, Бээжин./
21. 雍和宮庙务管理委员会规则制度, 北京., 2003. /Найралт Найрамдах сүмийн хийдийн харьят газрын журам тогтоол, Бээжин., 2003./
22. 雍和宮木板佛画, 北京., 2004. /Найралт найрамдах сүм дэх модон барын бурханы зургууд, Бээжин., 2004./
23. 雍和宮藏传佛教造像艺术, 北京., 2006. /Найралт найрамдах сүм дэх Төвөд уламжлалын бурханы шашины онцлогт хөрөг дүрийн урлаг, Бээжин., 2006./
24. 雍和宮金刚驱魔神舞, 北京., 2013. /Найралт найрамдах сүмийн цам, Бээжин., 2013./
25. 雍和宮满文档案译编(上, 下册), 北京., 2016. /Найралт найрамдах сүмийн Манж бичгийн эмхмэл дансны орчуулгын эмхэтгэл (дээд, доод дэвтэр), Бээжин., 2016.
26. 雍和宮庙务管理委员会规则制度汇编, 北京., 2016.1. /Найралт найрамдах сүмийн хийдийн харьят газрын журам тогтоолын эмхэтгэл, Бээжин., 2016./
27. 走进雍和宮, 北京., 1999. 10. /Найралт найрамдах сүмээр аялах нь, Бээжин., 1999.10./
28. 周润年, 塔娜. 雍和宮修学与教育体系研究, 北京., 2015. /Жөү рун ниан, Тана. Найралт найрамдах сүмийн сургалт, сурган хүмүүжүүлэх тогтолцоог судлах нь, Бээжин., 2015./
29. С.Янжинсүрэн. Дэлгэрийн чойрт мөрдөгдөж байсан дэг жаяг. Монголын буддын судалын орчин үеийн асуудал, УБ., 2015.
30. С.Янжинсүрэн. Барин Ёнзонгийн зохиосон нэгэн жаягийн тухай. Барин Ёнзон Дамцагдорж хувилгааны намтар, бүтээл судлал ЭШБХ. 2016.05.20.
31. С.Янжинсүрэн. Монгол дахь чойрын сургалтын дэг жаягаас. Mongolica, An International Journal of Mongol Studies. Vol.50, 2017